

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

| | | | |
|---|---|---------------------|---------------------------------|
| Ярилцлага өгөгчийн нэр | Дугарын Дашзэвэг | Дугаар | L102 |
| Оршин суугаа аймаг | Хэнтий | Оршин суугаа сум | Жаргалтхаан |
| Төрсөн газар | Жаргалтхаан сум | Төрсөн он | 1932 |
| Ажил мэргэжил | Өндөр настан | | |
| Лам байсан эсэх, Шавилан сүүж байсан сүм хийд | Тахилтын хийд, Цагаан суваргын хийд, Дашбалжирын хийд | Сүм хийдийн дугаар | ХЭЖХ 016, ХЭЖХ 012, ХЭЖХ 013 |
| Одоогийн сүм хийд | | Сүм хийдийн дугаар | |
| Ярилцлага авсан он сар өдөр | 2007 оны 6-р сарын 13 | Ярилцлага авсан хүн | Ж.Одгарьд |



Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Тахилтын хийд,
Цагаан суваргын хийд, Дашбалжирын хийд

Дайчингийн отог гэдэг хурал байсан гэдэг. Энд чинь Номун Хаан лам гэдэг хүн хорин хэдэн настайдаа баригдсан. Номун хаан лам гэж нэг хүн байсан юм. Олон лам нартай байсан болов уу цөөн ламтай байсан болов уу? Гэхдээ цөөн ламтай жижиг хийд байсан шиг байна лээ. Цөөндөө хэдхэн л байсан шиг юм байна лээ.

-Тэр үед лам нар олонтой байсан. Тэгэхээр цөөн гэхээр хэдэн лам байсан юм бол?

Одоо мэдэхгүй. Одоо энд хуучин юу байсан бэ? гэвэл тэг дөрвөлжин чулуу байгаад Шинжлэх ухааны хүрээлэнгийнхэн л гэсэн хүн ойртуулахгүй байж байгаад ачаад явсан. 51 машинтай байсан. Хэдэн оныг сайн мэдэхгүй байна.

-Тэгээд яг аль газар байсан бэ? Тахилтын хийдтэй ойрхон байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тахилтын хийдийн суурин дээр байсан. Энэ дээр хүүхдийн овоо гэж нэг овоо энэ толгой дээр байсан юм. 2001, 2002 оны үед манай Алтанцэцэгийг байхад хүүхэд нь чихэр олж идээд байсан чинь наадмын өдөр дээр нь идээ будаа тавьчихаад ухаад явчихсан байсан гэсэн. Дээр нь замгүй их юм байсан гэсэн. Тэр одоо юу байсан юм бүү мэд тэрийг мэдэх хүн ердөө байхгүй. Эндэхийн хамгийн настай хүн нь би байж байгаа юм. Миний дээр нэг өвгөн байсан юм. Шашин бол сайн мэдэх хүн байсан. Энэ хурал дээр байсан хүн. Энэ хавийг мэдэхээр өөр настай хүн байхгүй дээ. Бадамжав гуайгаас өөр хүн байхгүй. Хотод л байгаа даа.

-Одоо тэр дуганы суурь дээр суварга барьчихсан байна уу?

Тэр суварга бариад байгаагаас чинь баруун овоолоотой хөх хадтай шороо байж байгаа тэнд. Довжоонууд булангууд нь тэр баруун тийшээ тэр овгор дээгүүр байдаг юм. Ажиглаад харвал тэр дотор нэг овгор нүх ч байгаа. Дэчингомбо нүх ухаж байгаад хурлын ном энэ тэрийг шатаасан газар гэдэг байсан юм. Чүлүү тараасны тэнд нэг овоо шиг юм чинь бидний багад бүүр чингэлэгтэй тэрэг шиг юм байсан юм. Дээр нь гарахаар бурхан дээр гарлаа гэж загнаад л байдаг байсан. Тэрнээс өөр надад хэлэх барих юм юу ч байхгүй. Дээр үеийн настай хүн гэвэл юу ч байхгүй. Хайв чинь энд нэг Хамбын отог гэж жаахан хурал байхад байсан надаас 4,5-аар дүү юм чинь юугаа мэдэхэв. Хоролсүрэн гэдэг чинь уулын отгийн хүн. Манай энд Цэрэндамба гэж ухаан муутай хүүхэн байсан юм. Тэгсэн манайд орж ирснээ чи энийг хаанаас олоо вэ гэхэд нь үгүй ээ миний л юм шүү дээ гэсэн чинь, чи мөн сүйхээтэй хүн ээ, өөрийнхөө отгийн Да ламын ширээг авчихсан байна гэж байсан.

-Аль хийдийн Да лам юм бол?

Уугийн хурлынх.

-Да лам нь хэн гэдэг хүн байсан юм бол?

Мэдэхгүй.

-Энэ Цагаан суварга гэж тэмдэглэгдсэн байна. Энэ хаахнуур байдаг юм бол?

Энэ нь яг Хутагтын хүрээний хийд байгаа газрын зүүн хойд энгэр дээр Эрээт гэдэг цагаан туушуйтай юм байсан юм. Тэгэхээр тэрийг Цагаан суварга гэж би ойлгоод байсан юм. Тэгсэн тэр биш юм байна лээ. Цагаан суварганд мөргөнө гээд сонсдож л байсан, би суурийг нь хүртэл мэднэ. Энэ арын гол дотор, Мөрөнгийн цээжинд. Жаргалтхаан сумаас газрын зурган дээр үзэж болно. Зүр хүзүү гэдэг нь энүүхэн завсарт 2,3 хийдийн суурин байгаа. Цагаан суварга гэж тэнд байсан гэнэ лээ. Мөрөн голын эхэнд шахуу байгаа. Мөрөнг өгсөөд явбал тэрүүгээрх айлууд мэднэ байх. Зүр хүзүү гээд хөтөл дээгүүр давж байгаа. Тэр давдагийн архан талд хонхор байлуу өвөрт нь баруун урагш харсан хонхор дотор довжоо сууринууд байдаг юм. Тэнд Цагаан суварга гэж байсан юм байна лээ. Алтан тусгал гэдэг уулын зүүхэн урд энгэр дээр байсан.

-Урд талд Дашбалжир гээд нэг уул байна л даа. Улаан худгийн тэнд бас нэг түүрх байна? Энэ ямар хийд байсан юм бол?

Мэдэхгүй. Улаан худгийн хурал гэж би лав дуулаагүй.

-Өөр энэ судалгаанд гараагүй таны мэдэж байгаагаар тэнд нэг түүрх байгаа, хурал хүрж байсан гэсэн юм байна уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өөр энэнээс гадна байхгүй. Шиврийн хурал, Тахилтын хурал, хамбын хурал энэ тэрийг л мэднэ дээ. Дэчингийн хурал гэж байгаа, Хүүхэн Хутагтын хүрээ, Цагаан суварга нь орж байна.

Гичигний суурины тэнд одоо суварга босгочихсон морь уралдуулж наадам хийдэг юм.

-Гомбожав гэдэг хүнийг Гичигний хурлын талаар мэдэж магадгүй гэж байсан?

Гомбожав гэдэг наян хэдтэй өвгөн бий. Яг тэндэхийн унаган хүн. Багадаа манай энд ирсэн хүн. Гэхдээ арван хэдтэйдээ ирсэн юм. Гомбожав гуайгаас өөр мэдэх настай хүн бараг байхгүй байх. Улаан худгийг асуух гэж байгаа бол аймагт манай сумын засаг даргын аав Тангуудорж гэдэг хүн байгаа. Тэр л нэг гадарлаж магадгүй, 80 гарсан өвгөн байгаа. Тэрний яг өсөж төрсөн нутаг нь тэр Улаан хутагт. Манай тахилтын талаар Бадамжав гуайгаас сайн мэдэх хүн байхгүй. Би бол бага байсан юм чинь. Одоо бол би далан хэдтэй.

-Энэ хэдийн талаар аман, хууч яриа байвал ярьж өгөөч? Түүх, үлгэр байвал бас ярьж өгөөч?

Аан тийм юм одоо байхгүй ээ.

-Дайчингийн отог гэж чухам юуг ярьдаг байсан юм бол?

Мэдэхгүй одоогийхоор баг юмүү баригад юмүү байсан байх.

-Дайчин гэдэг нь?

Дайчин гэдэг нь тэргүүлж байсан хүний л нэр юм болов уу даа. Энүүхнийг Дайчингийн отог, Хутагтын хүрээнээс нааш чинь Номун хааны отог гэж байгаа. Тэр баруунтай Хамбын отог гээд байгаа юм, цаашаа болохоор Шивэрийн отог болно. Урагшаа Баатарын хошуу ,тэгээд урагшаагаа Завилаа, Гичиг гэж байгаа. Ийм л хуваагдсан газрууд байдаг юм байна лээ.

-Дайчингийн хурал, Дайчингийн отог гэж байгаа. Цэрэндорж гуайн яриаг сонсоход Дайчингийн хурал гэдэг нь эрдэмтэй лам нараа занданшуулж байсан юмуу даа. Тэр талаар?

Тэр тухай мэдэгдсэн юм ер байхгүй. Тэр лам баригдсан, их лам тэр байсан л гэж ярьдагаас биш өөр зүйл мэдэхгүй.

-Тахилтын хийдийн хаагдсан нураагдсан нь хэдэн онд юм болоо?

Мэдэхгүй. Намайг мэдээ ороход л тэнд ганц байшин байдаг байсан. Ганц байшингийн тэнд овгор чулуу байсан.

Миний мэдэх л тэр. Өмнө нь сүм хийд байсан гээд замгүй ярьдаг юм.